



СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ,  
ЗАЛУУЧУУДЫН ЯАМ

## ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН

**Дотоод аудитын нэр:** Санхүүгийн дотоод аудит

**Хамрагдсан байгууллага:** Сүхбаатар аймгийн Биеийн тамир, спортын газар

**Тайлангийн код:** СХШУДАГ-2026/ДА/05

Улаанбаатар хот

2026 он

## АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР .....	1
1. ТАНИЛЦУУЛГА.....	2
1.1. Байгууллагын тухай .....	2
2. АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ .....	3
2.1. Аудитын зорилго: .....	3
2.2. Аудитын хамрах хүрээ, хязгаарлалт .....	3
2.3. Аудитын арга, аргачлал .....	4
2.4. Өмнөх шалгалтын талаар .....	4
3. ЗАСАГЛАЛ, ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА, ДОТООД ХЯНАЛТЫН ТӨЛӨВШИЛ .....	5
3.1. Засаглалын удирдлагын талаар.....	5
3.2. Эрсдэлийн удирдлагын талаар .....	5
3.3. Дотоод хяналтын талаар.....	5
4. Санхүүгийн үйл АЖИЛЛАГААНЫ талаар .....	5
5. АУДИТЫН ҮР ДҮН .....	7
5.1. Засаглал, дотоод хяналт, нийтлэг мөрдөгдөх хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар.....	7
5.2. Санхүүгийн үйл ажиллагааны чиглэлээр. ....	8
5.3. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн чиглэлээр .....	8
6.НЭГДСЭН ДҮГНЭЛТ .....	9
7. ЗӨВЛӨМЖ.....	9

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

СХШУДАГ	Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар
ХЗЭ	Хувьсгалт залуучуудын эвлэл

## 1. ТАНИЛЦУУЛГА

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10-д заасан “Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитыг хэрэгжүүлэх”, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 7.2, 7.3, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, сайдын дэргэдэх “Дотоод аудитын хорооны 2026 оны төлөвлөгөө”, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын Сайдын 2026 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн А/101 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн зарим харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, дотоод аудит хийх” удирдамжийн дагуу 2026 оны 03 дугаар сарын 26-ны өдрөөс эхлэн СХШУДАГ-ын дарга Ч.Энх-Амгалан ахалж, тус газрын ахлах шинжээч Ц.Алтанхуяг Сүхбаатар аймгийн Биеийн тамир, спортын газрын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудитыг гүйцэтгэлээ.

### 1.1. Байгууллагын тухай

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1947 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 18 дугаар хурлын тогтоолоор ХЗЭ-ийн Төв Хорооны дэргэдэх Биеийн тамир спортын төв зөвлөлийг Сайд нарын Зөвлөлийн дэргэдэх Биеийн тамир ба спортын хэргийг эрхлэх хороо болгон өөрчилж, тус хорооны дүрмийг баталжээ. Уг дүрмэнд “Аймаг, хотын захиргааны дэргэдэх Биеийн тамир спортын хороог удирдана” гэж заасан байна. Энэхүү тогтоолын дагуу Сүхбаатар аймгийн Захиргааны дэргэд 1948 онд Биеийн тамирын хороо анх байгуулагджээ. 1960 оноос Биеийн тамирын “Сүхбаатар” нийгэмлэг, 1979 оноос аймгийн Биеийн тамир, спортын хороо, “Сүхбаатар спорт клуб”, 1991 оноос аймгийн Залуучуудын спортын хороо гэж нэрлэгдэх болсон байна.

Монгол Улсын Засгийн газрын 1994 оны 3 дугаар сарын 2-ны өдрийн 50 дугаар тогтоолоор аймгийн Биеийн тамир, спортын төв, 2001 оноос аймгийн Биеийн тамир, спортын хороо, Засгийн газрын 2008 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 67 дугаар тогтоолоор 2009 оноос аймгийн Биеийн тамир спортын газар болжээ.

Засгийн газрын 2013 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 146 дугаар тогтоолын дагуу аймгийн Засаг даргын 2013 оны 7 дугаар сарын 17-ны өдрийн А/291 дугаар захирамжаар аймгийн Соёл, спорт, аялал жуулчлалын газар шинээр байгуулагдсан байна.

Харин Засгийн газрын 2016 оны 8 дугаар сарын 3-ны өдрийн 9 дүгээр тогтоолоор эргээд аймгийн Биеийн тамир спортын газар болж ажилласан байна.

Аймгийн Засаг даргын 2019 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн А/334 дүгээр захирамжаар 34 хүний орон тоотой батлагдаад байсан бөгөөд 2023 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн А/285 дугаар захирамжаар 48 хүний орон тоотой батлагдсан.

Аймгийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн А/39 дүгээр захирамжаар 53 хүний орон тоо батлуулсан хэдий ч улсын төсвөөс орон тооны цомхотгол хийсний дараа 39 орон тооны төсвийн санхүүжилт авч ажиллаж байна.

Байгууллагын регистрийн дугаар 9051422, үндсэн үйл ажиллагааны 100120034010, нэмэлт санхүүжилтийн 100120034410, орон нутгийн төсвөөс санхүүжих 100120035009 тоот харилцах дансаар бэлэн, бэлэн бус төлбөр тооцоог хийж иржээ.

Аймгийн Засаг даргын 2023 оны 04 дүгээр сарын 04-ны өдрийн Б/28 дугаар захирамжаар Ж.Идэрмөнхийг Сүхбаатар аймгийн Биеийн тамир, спортын газрын даргын албан тушаалд томилсон байна. Аудитын хамрах хугацаанд дээрх шийдвэрийн дагуу

нэгдүгээр гарын үсгийг Ж.Идэрмөнх одоог хүртэл, хоёрдугаар гарын үсгийг нягтлан бодогчоор 2024 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн Б/25 дугаар тушаалаар томилогдсон Ц.Цацралтуяа нар тус тус зурж хөрөнгө, мөнгийг захиран зарцуулжээ.

Тус байгууллага нь 2025 оны хагас болон IV улирлын санхүү, татвар, нийгмийн даатгалын тайлангуудыг хуулийн хугацаанд нь холбогдох байгууллагуудад гарган өгч баталгаажуулсан.

#### Бүтэц зохион байгуулалт

Сүхбаатар аймгийн биеийн тамир, спортын газар нь Захиргаа аж ахуйн хэлтэс-19, Спортын хэлтэс-10, Биеийн тамирын хэлтэс-3, Усан спорт чийрэгжүүлэлтийн хэлтэс-12, нийт 44 орон тоотой боловч орон тооны цомхотголоор 5 орон тоо хасагдсан, 4 хэлтэстэй үйл ажиллагаа явуулж байна.

Засаглах удирдлага: Аймгийн Биеийн тамир, спортын газрын даргын тушаалаар 10 зөвлөл ажиллаж байна.

- 2024 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн А/23 тушаалаар “Байгууллагын ахмадын зөвлөл байгуулах тухай”
- 2024 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн А/47 тушаалаар “Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус байнгын комисс томилох, түүний ажиллах журам батлах тухай”
- 2025 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн А/06 тушаалаар “Байгууллагын дэргэдэх баримт нягтлан шалгах комиссын бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай”
- 2026 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн А/13 тушаалаар “Байгууллагын гэр бүл, хүүхэд, эцэг эхийн зөвлөл байгуулах тухай”
- 2026 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн А/14 тушаалаар “Байгууллагын дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах комисс байгуулах тухай”
- 2026 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн А/15 тушаалаар “Байгууллагын өмч хамгаалах зөвлөл байгуулах тухай”
- 2026 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн А/16 тушаалаар “Байгууллагын жөндөрийн салбар хороо байгуулах тухай”
- 2026 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн А/17 тушаалаар “Байгууллагын улаан загалмайн сайн дурын бүлэг байгуулах тухай”
- 2026 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн А/18 тушаалаар “Спорт цогцолбор, усан спортын төв, спортын А заалны өрөө тасалгаа, объектийн галын аюулгүй байдал, гамшиг ослоос сэргийлэн ханган ажиллах тухай”
- 2026 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн А/19 тушаалаар “Байгууллагын ёс зүйн хороо байгуулах тухай”

## **2. АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ**

### **2.1. Аудитын зорилго:**

Тус байгууллагын засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын үйл явцын үр нөлөөтэй байдлыг үнэлж, төсөв санхүүгийн үйл ажиллагаанд санхүүгийн аудит хийн дүгнэж, илэрсэн алдаа дутагдлыг арилгуулах, зөвлөмж өгөх байдлаар байгууллагын үйл ажиллагааг сайжруулах зорилго баримтлан ажилласан.

### **2.2. Аудитын хамрах хүрээ, хязгаарлалт**

Хамарсан хүрээ: Тус байгууллагын 2025 оны IV улирлын байдлаар тасалбар болгон санхүүгийн үйл ажиллагаа (засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналт, төсөв,

санхүүгийн бүртгэл тооцоо, хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр)-нд байдалд санхүүгийн дотоод аудитыг гүйцэтгэсэн.

**Хязгаарлалт:** Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газар нь тус байгууллагын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд санхүүгийн аудит хийж “Түүвэрт хамрагдсан” тул уг тайлангийн хамарсан хүрээгээр энэхүү хяналт шалгалтыг хязгаарлаж, итгэл хүлээлгэсэн болно.

### 2.3. Аудитын арга, аргачлал

Сангийн сайдын 2019 оны 268 дугаар тушаалаар баталсан “Улсын салбарын дотоод аудитын аргачлал”, Соёлын сайдын /хуучин нэрээр/ 2022 оны А/118 дугаар тушаалаар баталсан “Дотоод аудитыг гүйцэтгэх аргачлал”-ыг мөрдөж санхүүгийн аудитыг гүйцэтгэсэн болно.

Аудитад дараах хууль эрх зүйн актуудыг шалгуур болго. Үүнд:

- ✓ Төрийн албаны тухай хууль;
- ✓ Төсвийн тухай хууль;
- ✓ Нягтлан бодох бүртгэлийн тухай;
- ✓ Төрийн хяналт шалгалтын тухай хууль;
- ✓ Төрийн аудитын тухай хууль;
- ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль;
- ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- ✓ Шилэн дансны тухай хууль;
- ✓ Хөдөлмөрийн тухай хууль;
- ✓ Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль;
- ✓ Нийтийн биеийн тамирын тухай хууль;
- ✓ Биеийн тамирын тухай хууль;
- ✓ Нийгмийн даатгалын тухай хууль;
- ✓ Бусад холбогдох хууль тогтоомж, эрх зүйн акт.

### 2.4. Өмнөх шалгалтын талаар

Тус байгууллагын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газар санхүүгийн аудит хийж гүйцэтгэсэн. Аудитын дүнгээр 2 нэр төрлийн алдаа зөрчил илэрч шалгалтын явцад 1 залруулах бичилт хийгдэж 1 зөвлөмж өгсөн байна. Үүнд:

Шийдвэрийн төрөл	Аудитын байгууллагын тогтоосон акт, албан шаардлага, зөвлөмжийн товч утга	Мөнгөн дүн мян төг	Хэрэгжүүлсэн байдал
Залруулах	Үндсэн хөрөнгө /бүртгэлд залруулсан/	124,064.0	Спорт цогцолборын газрыг байгууллагын санхүүгийн тайлан, данс бүртгэлд тусгаагүй нь санхүүгийн мэдээллийн “иж бүрэн байх”, “үнэн зөв байдал” зарчимтай нийцэхгүй, хөрөнгийн бүртгэл, хяналт, ашиглалтад тодорхойгүй байдал үүсгэж, санхүүгийн тайлангийн бодоит байдлыг алдагдуулах эрсдэлтэй байна.

Зөвлөмж	Албан хаагчдад үр дүнгийн урамшуулал олгохдоо Засгийн газрын 2023 оны 301 дугаар тогтоолд заасны дагуу бодитой, ил тод, хариуцлагатай байх зарчмыг баримтлан үнэлээгүй байна.	-	Зөвлөмжийг хэрэгжүүлж байгаа
Дүн		124,064.0	

### 3. ЗАСАГЛАЛ, ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА, ДОТООД ХЯНАЛТЫН ТӨЛӨВШИЛ

#### 3.1. Засаглалын удирдлагын талаар

##### Хөдөлмөрийн дотоод журмын талаар:

Байгууллагын даргын 2023 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн А/19 тушаалаар “Хөдөлмөрийн дотоод журам”-ыг баталсан байна.

##### Тушаал шийдвэрийн талаар:

Тус байгууллага нь 2025 оны жилийн эцсийн байдлаар үндсэн үйл ажиллагааны чиглэлээр “А” индексийн 99, боловсон хүчний чиглэлээр “Б” индексийн 53, нийт 152 тушаал төлөвлөж гаргасан байна.

Байгууллагын засаглалын талаар ажлын баримт АБ1002-оор ерөнхий 3 асуултын хүрээнд 7 дэд асуулга авч дотоод аудитын аргачлалд заасан 8 шалгуураар үнэлгээ хийхэд төлөвшил нь “Давтамжтай буюу 2-р түвшин”-нд байна

#### 3.2. Эрсдэлийн удирдлагын талаар

Байгууллагын эрсдэлийн удирдлагын үйл явцын талаар ажлын баримт АБ1003-аар 12 асуулга авч, дотоод аудитын аргачлалд заасан 8 шалгуураар үнэлгээ хийхэд төлөвшил нь “Эхлэлийн буюу 1-р түвшин”-нд байна.

#### 3.3. Дотоод хяналтын талаар

Дотоод хяналтын тухайд газрын даргын 2025 оны А/22 дугаар тушаалаар дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах комиссыг 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан. Уг тушаалын хавсралтаар комиссын ажиллах журмыг баталсан байна. Байгууллагын дотоод хяналтын 2025 оны төлөвлөгөөнд 4 чиглэлийн хүрээнд 12 арга хэмжээ төлөвлөсөн. Байгууллагын үндсэн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж тайлагнасан, санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлсэн тайлан бичигдээгүй, шууд жилийн ажлын төлөвлөгөөний биелэлтийг гаргасан байна. Дотоод хяналтын үйл явцын талаар ажлын баримт АБ1004-өөр 8 асуулга авч дотоод аудитын аргачлалд заасан 4 чиглэлийн 13 шалгуураар үнэлгээ хийхэд төлөвшил нь “Эхлэлийн буюу 1-р түвшин”-нд байна.

### 4. САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

#### Төсвийн төлөвлөлт

Байгууллагын 2025 оны төсвийн төслийг 2,787,513.0 мянган төгрөгөөр боловсруулан ССАЖЗЯ -нд хүргүүлсэн.

ССАЖЗЯ-аас тус байгууллагын 2025 оны төсвийг

Тус байгууллагын 2025 оны урсгал санхүүжилтэд улс, орон нутгийн төсвөөс 1 хөтөлбөр 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,313,171.3 мянган төгрөгийн төсөв батлагдсан.

1,313,171.3 мянган төгрөг болж  
1,474,341.7 мянган төгрөгөөр  
буурсан байна.

- Үндсэн үйл ажиллагааны зардалд 1,310,171.3 мянган төгрөг
- Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшууллын зардалд 143,534.8 мянган төгрөг
- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 924,979.6 мянган төгрөг

Тус байгууллагын 2025 оны IV улирлын санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 34,891.1 мянган төгрөгөөр буюу 0.5 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, бараа материал, өр төлбөр, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	0	0	0
Бараа материал	88,657.5	102,893.9	14,236.4
Үндсэн хөрөнгө	7,010,304.4	6,961,176.8	-49,127.6
Нийт хөрөнгө	<b>7,098,961.9</b>	<b>7,064,070.8</b>	<b>-34,891.1</b>
Богино хугацаат өр төлбөр	0	215,795.7	215,795.7
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	7,098,961.9	6,848,275.1	-250,686.8
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	<b>7,098,961.9</b>	<b>7,064,070.8</b>	<b>-34,891.1</b>

Бараа материалын дансны үлдэгдэл 14,236.4 мянган төгрөгөөр өссөн байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 112,467.5 мянган төгрөгийн бараа материалын худалдан авч, 98,231.1 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж тайлагнасан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 6,961,176.8 мянган төгрөг болж -49,127.6 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь тайлант хугацааны 258,889.5 мянган төгрөгийн үнэ бүхий үндсэн хөрөнгө орлого авч, 248,828.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг актлаж, 304,368.6 мянган төгрөгийн цэвэр элэгдэл байгуулсантай холбоотой байна.

Тайлан хугацаанд богино хугацаат өр төлбөр 2,772,679.3 мянган төгрөгөөр нэмэгдэж, 2,556,883.6 мянган төгрөгөөр буурч байгууллагад төлөх өглөг 215,795.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Энэ нь орон нутгийн төсвийн санхүүжилт тасарсантай холбоотой түлш халаалт, цэвэр бохир усны төлбөрийн өр үүссэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 6,848,275.1 мянган төгрөг болж, 250,686.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр 2025 оны IV улиралд улсын төсвөөс 1,313,171.3 мянган төгрөг, Засаг даргын нөөц хөрөнгөөс 136,957.2 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 924,979.6 мянган төгрөг, Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 112,798.2 мянган төгрөг, нийт 2,556,901.6 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар харуулав.

**Байгууллагын 2025 оны улсын төсвийн жилийн эцсийн байдлаарх  
төсвийн гүйцэтгэлийн тайлангийн дүн**

№	Үзүүлэлт	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Зөрүү + -	Хувь
71704	Соёл урлаг	1,313,171.3	1,313,082.1	89.20	99.99
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	1,310,171.3	1,310,082.1	89.20	99.99
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл	1,148,269.1	1,148,269.1	0.00	100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх зардал	143,534.8	143,534.8	0.00	100.00
2103	Байр ашиглалттай холбоотой зардал		-	0.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	9,251.1	9,250.7	0.40	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		-	0.00	
2107	Томилолт, зочны зардал	970.4	970.4	0.00	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардал	6,680.9	6,591.5	89.40	98.66
2109	Бараа үйлчилгээ бусад	1,465.0	1,465.0	0.00	100.00
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж	2,000.0	2,000.0	0.00	100.00
2132	Нэг удаагийн тэтгэмж	2,000.0	2,000.0	0.00	100.00

**5. АУДИТЫН ҮР ДҮН**

**5.1. Засаглал, дотоод хяналт, нийтлэг мөрдөгдөх хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар.**

<b>Илэрсэн асуудал 1.</b> Дотоод хяналт шалгалтыг иж бүрэн хэрэгжүүлээгүй байна.	
Дотоод аудитын хамарсан хүрээ: Засаглал, эрсдэлийн удирдлагын төлөвшлийг тодорхойлох, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянаж үр нөлөөг үнэлэх.	
<b>Шалгуур үзүүлэлт:</b>	<b>Илэрсэн алдаа, дутагдал:</b>
Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ын 1.3. Аж ахуйн нэгж, байгууллага нь энэхүү нийтлэг журамд нийцүүлэн, өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон "Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам"-тай байна.	<ul style="list-style-type: none"> <li>Дотоод хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу удирдамж баталсан боловч хяналт шалгалтыг иж бүрэн гүйцэтгээгүй, дотоод хяналт шалгалтын төлөвлөгөөний хэрэгжилт хангалтгүй байна;</li> </ul>
<b>Шалтгаан</b>	
Хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар албан тушаалтны үйлдэл, эс үйлдэл.	
<b>Үр нөлөө</b>	
Байгууллагын үндсэн үйл ажиллагаа, төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд эрсдэл үүсэх.	
<b>Дүгнэлт:</b>	
Байгууллагын үндсэн үйл ажиллагаа, төсөв санхүүгийн зарцуулалтад удирдамжийн дагуу дотоод хяналт иж бүрэн хэрэгжүүлээгүй байна.	
<b>Зөвлөмж:</b>	
1. Дотоод хяналтын ажлын төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтыг зохион байгуулан, тайлангаар илэрсэн алдаа дутагдлыг залруулан, үр дүнг хамт олонд мэдээлж байх;	

## 5.2. Санхүүгийн үйл ажиллагааны чиглэлээр.

<b>Илэрсэн асуудал 1.</b> Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг мөрдөөгүй байна.	
Дотоод аудитын чиглэл: Батлагдсан төсвийн хүрээнд албан хаагчдад нэг удаагийн тэтгэмж, урамшуулал олгох, анхан шатны баримт бүртгэл хөтлөлтийг хянаж үр нөлөөг үнэлэх.	
Нөхцөл байдал: Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын дагуу 2025 онд 9 албан хаагчид 1,240.0 мянган төгрөгийн буцалтгүй тусламж, нэг албан хаагчдад төрийн албаны өндөр насны тэтгэвэрт гарсны нэг удаагийн 36,895.0 мянган төгрөгийн тэтгэмж олгох шийдвэр гаргасан байна.	
<b>Шалгуур үзүүлэлт:</b>	<b>Илэрсэн алдаа, дутагдал:</b>
“Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” –хуулийн 11.1.Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно.	<ul style="list-style-type: none"> <li>Байгууллагын удирдлагад хөдөлмөрийн дотоод журмын дагуу 180.0 мянган төгрөгийн буцалтгүй тусламж үзүүлсэн 2025 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн Б/38 дугаар тушаалыг төсвийн шууд захирагч өөрөө баталсан байна. Энэ нь “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” – хуулийн 11.1 дэх заалтыг зөрчсөн байна.</li> </ul>
<b>Шалтгаан</b>	
Хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар албан тушаалтны үйлдэл, эс үйлдэл	
<b>Үр нөлөө</b>	
Хууль тогтоомж хэрэгжихгүй байх, ашиг сонирхлын зөрчил үүсэх	
<b>Дүгнэлт:</b>	
Нийтийн албанд хувийн ашиг сонирхлыг зохицуулах хуулийг мөрдөж ажлаагүй байна.	
<b>Зөвлөмж:</b> Байгууллагын удирдлага нь хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаарх хууль тогтоомжийг мөрдөж ажиллах;	

## 5.3. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн чиглэлээр

<b>Илэрсэн асуудал 1.</b> Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын 68 удаагийн гүйлгээг 7 хоногийн дотор мэдээлэх хугацааг хоцроож мэдээллийг иж бүрэн, үнэн зөв, бодиттой байх шаардлагыг хангаж бүрэн мэдээлээгүй байна.	
Дотоод аудитын чиглэл: Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон эрх зүйн актын хэрэгжилт.	
<b>Шалгуур үзүүлэлт:</b>	<b>Илэрсэн алдаа, дутагдал:</b>
Шилэн дансны тухай хуулийн 6.3. Энэ хуулийн 6.1.2-т заасан мэдээлэл дараах байдлаар илэрхийлэгдсэн байна: 6.3.5. Хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалт; Шилэн дансны тухай хуулийн 6.4.Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ: 6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр; 6.4.7. Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт; 6.4.8. Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн	<ul style="list-style-type: none"> <li>Тайлант хугацаанд 36 удаагийн 904,452.0 мянган төгрөгийн зарлагын гүйлгээнээс 33 удаагийн 832,886.6 мянган төгрөгийн зарлагын гүйлгээг 7 хоногийн дотор мэдээлэх хуулийн хугацаа хоцроож мэдээлсэн байна.</li> <li>Тайлант хугацаанд 42 удаагийн 2,497,953.6 мянган төгрөгийн орлогын гүйлгээг мэдээлэхээс 35 удаагийн 2,019,152.6 мянган төгрөгийн орлогын гүйлгээг 7 хоногийн дотор мэдээлэх хуулийн хугацааг хоцроож мэдээлсэн байна.</li> <li>2025 оны 01-р сард байгууллагын батлагдсан орон тоонд орсон</li> </ul>

хэвшлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр	өөрчлөлтийн мэдээллийг хуулийн хугацаа хоцроож мэдээлсэн. • Тайлант хугацаанд 6 удаагийн мэдээллийг 7 хоногийн дотор мэдээлэх хуулийн хугацааг хоцроож мэдээлсэн.
<b>Шалтгаан</b>	
Шилэн дансны шинэчилсэн цахим хуудсанд мэдээлэл байршуулах аргачлал, зааврыг бүрэн хэрэгжүүлээгүй үйлдэл, эс үйлдэл.	
<b>Үр нөлөө</b>	
Нийтийн мэдээллийн ил тод байдлыг хангах тухай хууль, Шилэн дансны тухай хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдахгүй байх.	
<b>Дүгнэлт:</b> Тус байгууллага нь 2025 оны жилийн эцсийн байдлаар шилэн дансанд 23 нэр төрлийн мэдээллийг 171 талбарт мэдээлэхээс хуулийн хугацаа хоцроож 1 талбарт мэдээлсэн, мэдээллийн үнэн зөв, бодиттой, иж бүрэн байх зарчмыг бүрэн хангасан байдлыг шалгахад 28 алдаа гаргасан байна	
<b>Зөвлөмж:</b>	
1. Шилэн дансны тухай хуулийн мэдээллийг хуульд заасан хугацаанд үнэн зөв, бодитой, иж бүрэн мэдээлж байх;	

## 6.НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Сүхбаатар аймгийн Биеийн тамир, спортын газрын 2025 оны эцсийн төсөв санхүүгийн үйл ажиллагаанд илэрсэн алдаа, дутагдлын үр нөлөө, цаашид үүсэх эрсдэлийг үнэлээд дотоод хяналтыг сайжруулах шаардлагатай гэж дүгнэв.

Аудитаар илэрсэн алдаа дутагдалыг залруулах, аудитын тайлангаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг ханган ажиллаж, биелэлтийг цаглаварт хугацааны дотор СХШҮДАГ-т албан бичгээр хавсарган ирүүлэхийг мэдэгдье.

## 7. ЗӨВЛӨМЖ

Төсвийн шууд захирагч, дарга Ж.Идэрмөнх танаа

Хугацаа

Зөвлөмж 1. Дотоод хяналтын ажлын төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтыг зохион байгуулан, тайлангаар илэрсэн алдаа дутагдлыг залруулан, үр дүнг хамт олонд мэдээлж байх;

2026 оны 06-р сарын 25-ны дотор

Зөвлөмж 2. Байгууллагын удирдлага нь хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаарх хууль тогтоомжийг мөрдөж ажиллах;

Нягтлан бодогч Ц.Цацралтуяа танд

Зөвлөмж 1. Шилэн дансны тухай хуулийн мэдээллийг хуульд заасан хугацаанд үнэн зөв, бодитой, иж бүрэн мэдээлж байх;

2026 оны 04-р сарын 25-ны дотор

СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН ЯАМ

---оОо---